



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 онь 01 сарын 13 өдөр

Дугаар А/07

Номгон

Төрийн байгууллагын зарим үйл ажиллагааг  
цахим баримт бичгээр хөтлөх тухай


Цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Агентлаг, сум, байгууллагын удирдах ажилтны шийдвэр, албан бичиг төлөвлөлтийн хяналтыг цахим баримт бичгээр боловсруулан хянах, баталгаажуулах, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол шийдвэрлэлтийг цахим системээр хүлээн авч шийдвэрлэх, хариуг хүргүүлэхээр боловсруулагдсан [eoffice.bayanhongor.gov.mn](http://eoffice.bayanhongor.gov.mn) цахим системийг агентлаг, сум, байгууллагууд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлсүгэй.

2.Агентлаг, сум, байгууллагуудын цахим системийн ашиглалт, хэрэглээнд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

3.Цахим системийн ашиглалт, хэрэглээг сум, байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд хяналт тавьж, чиг үүргээр ханган ажиллахыг агентлаг, сум байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642310016

D:\2023 он\захирамж-2023\Захирамж-2023 он.docx